

**ЖУРМЫН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛД
ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВАХААР ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.**

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ**

ХОЁР. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2.5.4 Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 2.2-т дурдсан эрсдэлийн үнэлгээгээр бага эрсдэлтэй гэж тодорхойлогдсон харилцагчийн хувьд Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон салбарын эрсдэлийн үнэлгээтэй нийцтэй байдлыг харгалзан үзэж харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.2-д заасан хүрээнд хялбаршуулан хэрэгжүүлж болно.

ТАВ. ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ХЯЛБАРШУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 дэх заалтыг хасах
5.3 дахь заалтыг хасах

АРВАН ДӨРӨВ. САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

14.1. МэҮЭ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 6¹ дүгээр зүйл болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйл болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.

14.2. Тагнуулын байгууллага болон Терроризмтой тэмцэх зөвлөл жагсаалтыг хяналт шалгалтын чиг үүрэгтэй эрх бүхий байгууллага болон нийтэд шуурхай мэдээлж, албан ёсны цахим хуудсан байршуулсан үед МэҮЭ нь хориг арга хэмжээний жагсаалт болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд /цаашид “жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд” гэх/тэй шууд болон шууд бусаар холбоотой аливаа харилцагч, гүйлгээ, хөрөнгө, мөнгө байгаа эсэхийг шалгана.

14.3. МэҮЭ нь жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд болон тэдгээрийн нэрийн өмнөөс шууд болон шууд бусаар эсхүл тэдгээрийн зааврын дагуу үйл ажиллагааг явуулж байгаа этгээдийн хөрөнгө, мөнгө байгаа гэж үзвэл Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6¹.2 болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.6 болон 24 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

14.4. МэҮЭ нь энэ журмын 14.3-д заасан үүргээ хэрэгжүүлэхдээ Тагнуулын ерөнхий газрын даргын баталсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой

тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-ын хавсралт маягт №5 /Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийн тайлан/-д заасан мэдээллийг тагнуулын байгууллага, санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлнэ.

14.5. МэҮЭ нь энэ журмын 14.3-д заасан үүргээ нэн даруй хэрэгжүүлж хэрэв жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг нягтлах бол “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-ын хавсралт маягт №6 /Мэдээллийг нягтлахад туслалцаа хүсэх маягт/-д заасан мэдээллийг тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

14.6. Царцаасан мөнгөн хуримтлал, хөрөнгөөс тэдгээрийн үндсэн хэрэглээний зардал, тодорхой төрлийн төлбөр, нэн шаардлагатай зардал, үйлчилгээний хураамж буюу гэнэтийн зайлшгүй зардал зэргийг төлж барагдуулах шаардлагатай талаарх хүсэлтийг МэҮЭ нь “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал”-ын хавсралт маягт №7 /Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл хүсэх тухай маягт/-ын дагуу тагнуулын байгууллагад хүсэлт гаргана.

14.7. МэҮЭ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн Зөвлөл болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн Засгийн газраас үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой баталсан хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль, журамд заасан шаардлагад нийцүүлсэн эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоотой байна. Үүнд:

14.7.1. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй холбоотой хөрөнгө, мөнгө МэҮЭ-д байгаа эсэхийг өөрийн мэдээллийн сангаас хайх, нэр тохирсон үр дүнгийн талаар тагнуулын байгууллагад мэдээлэх журамтай байх;

14.7.2. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг илрүүлэх, нэн даруй царцаах, тагнуулын байгууллага, санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үйл ажиллагаатай холбоотой журамтай байх;

14.7.3. жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгө, мөнгөнд харилцагч болон бусад этгээдийн зүгээс хандах оролдлогыг хянах, хязгаарлах журамтай байх;

14.7.4. тагнуулын байгууллагаас ирүүлсэн заавар, чиглэлийн дагуу жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд хөрөнгө, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх журамтай байх;

14.7.5. тагнуулын байгууллагаас ирүүлсэн жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн хөрөнгийг чөлөөлөх шийдвэрийг хэрэгжүүлэх журамтай байх.